



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,

Сэлэнгэ аймаг, 43081

Утас/Факс: (976)-7036-3040

Цахим шуудан: Selenge@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

2026.04.20

№ 257

танай _____

-ны № _____

-т

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Ц.НАРАНЧИМЭГ ТАНАА

Сэлэнгэ аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан болон хавсралт судалгааг гаргаж хүргүүлэв.

Хүлээн авч танилцана уу.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.БАТМӨНХ



4326070511

Албан бичиг А5 2026



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2026 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/36

Сүхбаатар сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/175 дугаар "Эрх шилжүүлэх тухай" тушаалын гуравдугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Сэлэнгэ аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл"-д хийсэн аудитын тайланг баталгаажуулсугай.


2.Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газар болон, Засаг дарга (Н.Лхагвадорж) нарт тус тус хүргүүлсүгэй.

3.Аудитаар тогтоосон албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг тогтоосон хугацааны дотор ирүүлэхийг аймгийн Засаг дарга (Н.Лхагвадорж)-д зөвлөсүгэй.

4.Аудитын ажлын болон нотлох баримтыг 2026 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг ахлах аудитор (Т.Болор)-т үүрэг болгосугай.

5.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор (Ц.Отгонбаяр)-т даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БАТМӨНХ

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



АУДИТЫН ТАЙЛАН

Аймаг, сумдын ОНХО, ОНХС-ийн худалдан авах ажиллагааг Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хугацаанаас өмнө зохион байгуулж, гэрээ байгуулаагүйгээс шалтгаалан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт 11,183.0 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна.

АУДИТЫН СЭДЭВ: СЭЛЭНГЭ АЙМГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Аудитын код: СЭА-2026/02-17/СТА-НА-НТГ

Цахим хуудас: www.audit.mn Сүхбаатар сум 2026 он	Дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх Утас: 7036-3040 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Ахлах аудитор: Ц.Отгонбаяр Утас: 7036-3036 Цахим хаяг: otgonbayarts@audit.gov.mn Аудитор: Ж.Цогт Утас: 7036-2442 Цахим хаяг: tsogtj@audit.gov.mn Аудитор: Б.Наранцэцэг Утас: 7036-2442 Цахим хаяг: narantsetsegba@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Тайланг бэлтгэсэн:

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар	Агуулга	1
	Товчилсон үгийн жагсаалт	2
	Нэг.Ерөнхий зүйл	3
Дарга, тэргүүлэх аудитор	ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ	4-5
Б. Батмөнх	БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГЫГ БОДИТОЙ ТӨЛӨВЛӨСӨН ҮҮ?	
Ахлах аудитор	1.1 Орон нутгийн төсвийн орлогыг холбогдох хууль эрхийн актуудад нийцүүлэн үндэслэлтэй төлөвлөсөн эсэх?	5
Ц.Отгонбаяр	1.2 Орон нутгийн төсвийн зарлагыг холбогдох хууль эрхийн актуудад нийцүүлэн, үндэслэлтэй төлөвлөсөн эсэх?	6
Аудитор	1.3 Төсвийн жилийн дундуур төсөвт тодотгол хийгдсэн эсэх?	9
Ж.Цогт		
Б.Наранцэцэг		
2026 оны 04 дүгээр сар	БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫГ БҮРЭН ТӨВЛӨРҮҮЛСЭН ҮҮ?	
Уг тайланг ҮАГ-ын цахим хуудаснаас үзнэ үү:	2.1 Татварын ба татварын бус орлогыг нэмэгдүүлэх нөөц боломжийг бүрэн ашигласан эсэх?	11
www.open.audit.mn	2.2. Төсөвт байгууллагуудын төлөвлөсөн өөрийн орлогыг бүрэн төвлөрүүлж, нэмэгдүүлэх нөөц боломжийг ашигласан эсэх?	14
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70362442, 70363036 дугаарын утас, selenge@audit.gov.mn хаягаар харилцана уу.	БҮЛЭГ 3. БАТЛАГДСАН ТӨСВИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ, ҮР ДҮНТЭЙ ЗАРЦУУЛСАН УУ?	
	3.1 Орон нутгийн төсвийн зарлагын гүйцэтгэл, түүний хэтрэлт хэмнэлтийн шалтгаан бодитой, үнэн зөв эсэх?	15
	3.2 Батлагдсан төсвийг холбогдох хууль, эрхийн актын хүрээнд, зориулалтын дагуу зарцуулсан эсэх?	17
	3.3 ОНХО болон ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжсэн эсэх?	20
ХАЯГ:	ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ	23
<u>Сэлэнгэ аймаг дахь төрийн аудитын газар</u>	АУДИТЫН ДҮГНЭЛТ	23
Аймгийн ЗДТГ-ын байр, Сүхбаатар сум, Сэлэнгэ аймаг-43080	ЗӨВЛӨМЖ	24
Монгол Улс		

Товчилсон үгийн жагсаалт

ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БОГ	Байгаль орчны газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ГХУСАХЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх аймгийн хяналтын зөвлөл
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
УИХ	Улсын Их Хурал
ХААГ	Худалдан авах ажиллагааны газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар

Нэг. Ерөнхий зүйл

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

1. Аудитын нэр:

Сэлэнгэ аймгийн 2025 оны төсвийн гүйцэтгэл

2. Аудитын код:

СЭА-2026/02-17/СТА-НА-НТГ

3. Аудит хийх бүрэн эрх, үндэслэл:

Аудитыг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4, Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэв.

4. Аудитын зорилт:

Сэлэнгэ аймгийн 2025 оны төсвийн орлого, зарлагыг үндэслэлтэй төлөвлөж, хэрэгжүүлсэн эсэх, гүйцэтгэлийг үнэн зөв илэрхийлсэн эсэхийг шалган, дүгнэлт, зөвлөмж боловсруулан, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулах, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг хийж гүйцэтгэв. Үүнд:

- *Орон нутгийн төсвийн орлого, зарлагыг бодитой төлөвлөсөн үү?*
- *Орон нутгийн төсвийн орлогыг бүрэн төвлөрүүлсэн үү ?*
- *Батлагдсан төсвийг зориулалтын дагуу, үр дүнтэй зарцуулсан уу?*

5. Аудитын хамрах хүрээ:

Аудитыг Сэлэнгэ аймгийн ИТХ-аас баталсан 2025 оны төсвийн орлого, зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэлийн мэдээ, тайлан, жилийн эцсийн санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтууд, холбогдох судалгаа болон бусад баримт материалд тулгуурлан гүйцэтгэв.

6. Аудитын арга зүй:

Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС- 300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит.Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудит”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудит”-ын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/71 дүгээр тушаалаар баталсан “Нийцлийн аудитын заавар, аргачлал”-ын дагуу аймаг, сумдын ЗДТГ, аймгийн Татварын газрын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл, санхүүжилттэй холбоотой баримт, материалд тулгуурлан дүн шинжилгээ хийх зэрэг

арга зүйг ашиглан аудитын асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулна.

7. Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт:

Төсвийн тухай хууль, Төрийн аудитын тухай хууль, Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хууль, Улсын Их Хурлын 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн баталсан “Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хууль”-д оруулсан нэмэлт өөрчлөлт, Татварын багц хуулиуд, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”, 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”, Аймгийн ИТХ-ын “Төсөв батлах тухай” 2024 оны 12, 2025 оны 43 дугаар тогтоолууд болон холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актуудыг тус тус шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

8. Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа:

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Батмөнх удирдаж, үе шатны чанарын хяналтыг ахлах аудитор Ц.Отгонбаяр гүйцэтгэн, ахлах аудитор Т.Болор, аудитор Ж.Цогт, О.Анхбаяр, Б.Наранцэцэг, Э.Энхбүрэн, Ч.Сугардорж нар 2026 оны 03 дугаар сарын 25-аас 04 дүгээр сарын 20-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэв.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Сэлэнгэ аймгийн 2025 оны төсвийн орлого нь татварын ба татварын бус орлого, улсын төсвийн орлогын болон ОНХНС-ийн шилжүүлэг, сумдад олгох санхүүгийн дэмжлэг, сумдаас авах татаас, төсөвт байгууллагуудын өөрийн орлогоос бүрдсэн бөгөөд уг эх үүсвэрээр орон нутгийн төсвийн 134 байгууллагын урсгал зардал, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ, ОНХС, хоршоо хөгжүүлэх сан зэрэг тусгай сангуудыг санхүүжүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын 2024 оны 12 дугаар тогтоолоор 2025 оны төсвийн орлогыг 83,837.2 сая төгрөгөөр, зарлагыг 81,649.8 сая төгрөгөөр, орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 2,187.4 сая төгрөгөөр тус тус төлөвлөж, баталсан байна.

Улсын төсөвт тодотгол хийсний улмаас аймаг, сумдын төсөвт тус бүр 1 удаа тодотгол хийж, аймгийн төсвийг **50,614.2** сая төгрөгөөр, сумдын төсвийг **99,923.9** сая төгрөгөөр, нийт төсвийг **150,538.1** сая төгрөгөөр эцэслэн баталсан байна.

Аймаг, сумдын орон нутгийн татварын болон татварын бус орлогыг **105,512.3** сая төгрөгөөр эцэслэн төлөвлөснөөс гүйцэтгэлээр **118,166.3** сая төгрөгийг төвлөрүүлж, **112.0** хувийн биелэлттэй тайлагнагдсан байна.

Сэлэнгэ аймгийн 2025 оны төсвийн зарлага *аймаг, сумд нийлсэн дүн*-ыг **150,538.1** сая төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр **117,668.6** сая төгрөг зарцуулж, 78.2 хувийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан байна.

БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГЫГ БОДИТОЙ ТӨЛӨВЛӨСӨН ҮҮ?

1.1 Орон нутгийн төсвийн орлогыг холбогдох хууль эрхийн актуудад нийцүүлэн үндэслэлтэй төлөвлөсөн эсэх?

Аймаг болон зарим сумдын татварын болон татварын бус суурь орлогыг өндрөөр төлөвлөж, баталсан байна.

1.1.1 Төсвийн тухай хуулийн 57, 58 дугаар зүйлийн 58.2-д заасан нөхцөл, чиг үүрэг, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам", аймгийн 2025 оны төсвийн төсөл, холбогдох бусад хууль эрх зүйн актуудыг үндэслэн Сэлэнгэ аймгийн 2025 оны төсвийн орлогыг төлөвлөсөн байна.

1.1.2 УИХ-аас Сэлэнгэ аймгийн 2025 оны орон нутгийн төсвийн суурь орлогыг 34,670.9 сая төгрөгөөр, ОНХС-ийн орлогын шилжүүлгийг 31,299.0 сая төгрөгөөр, сумын төсвөөс аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 13,140.0 сая төгрөгөөр зэрэг нийт **79,109.8** сая төгрөгийн орлого бүрдүүлж, улсын төсөвт **2,187.4** сая төгрөгийг төвлөрүүлэн **76,922.4** сая төгрөгийг зарцуулахаар баталж, ирүүлжээ.

1.1.3 Сэлэнгэ аймгийн ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 12 дугаар тогтоолоор дээрх орлогыг **4,727.4** сая төгрөгөөр нэмэгдүүлж, **83,837.2** сая төгрөгөөр */Дэлгэрэнгүйг хавсралт 1-д харуулав/* баталсан байна. Үүнд:

- *Татварын болон татварын бус орлогыг 6,057.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 40,680.9 сая төгрөгөөр,*
- *Сумын төсвөөс аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 8,304.6 сая төгрөгөөр бууруулан 4,835.4 сая төгрөгөөр,*
- *ОНХС-ийн орлогын шилжүүлгийг 31,299.0 сая төгрөгөөр,*
- *Төсөвт байгууллагын өөрийн орлогыг 47.0 сая төгрөгөөр,*
- *ОНХС-ийн урьд оны мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг 2,068.3 сая төгрөгөөр,*
- *Ерөнхий орлогын дансны урьд оны мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг 4,906.6 сая төгрөгөөр зэрэг.*

1.1.4 Татварын болон татварын бус орлогыг сүүлийн 3 жилийн гүйцэтгэлийн дунджаар тооцон төлөвлөхөөр зохицуулагдсан атал аймаг нь улсын тэмдэгтийн хураамжийг 3,654.9 сая төгрөгөөр, бусад орлогыг 991.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн баталсан байна.

1.1.5 2024 оны 12 дугаар сард хуралдсан сумдын ИТХ-аар 2025 оны төсвийн хянагдсан суурь орлогыг сумд (**10.0-199.2**) сая төгрөгөөр, Ерөө сум **1,978.0** сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн бол Мандал сум 812.5 сая төгрөгөөр бууруулж, нийт **60,303.0** сая төгрөгөөр баталсан байна.

Хүснэгт №1. Сумдын төсвийн орлогын төлөвлөлт

/сая төгрөг/

№	Сумд	Өмнөх оны гүйцэтгэл	Хянасан суурь орлого	Баталсан орлого	Орлогын зөрүү
1	Алтанбулаг	1,056.8	1,171.7	1,242.3	70.6
2	Баруунбүрэн	1,086.8	1,120.2	1,120.2	-
3	Баянгол	2,616.3	2,330.3	2,529.5	199.2
4	Ерөө	5,960.1	7,732.4	9,710.4	1,978.0
5	Жавхлант	452.7	461.2	471.2	10.0
6	Зүүнбүрэн	795.1	682.4	766.8	84.4
7	Мандал	13,330.9	13,206.1	12,393.6	(812.5)
8	Орхон	736.1	730.0	871.7	141.7
9	Орхонтуул	693.8	862.4	862.4	-
10	Сайхан	5,467.1	6,228.4	6,267.9	39.5
11	Сант	542.6	547.6	570.0	22.4
12	Сүхбаатар	14,693.0	15,427.2	15,523.2	96.0
13	Түшиг	707.7	933.0	933.0	-
14	Хушаат	591.6	587.8	601.3	13.5
15	Хүдэр	2,904.4	3,417.5	3,492.9	75.4
16	Цагааннуур	1,435.4	1,429.8	1,614.5	184.7
17	Шаамар	1,334.3	1,310.1	1,332.1	22.0
НИЙТ		54,404.7	58,178.1	60,303.0	2,124.9

Эх сурвалж: Сумдын ИТХ-ын төсөв баталсан тогтоолууд

1.1.6 Сумдын татварын болон татварын бус орлогын төрлүүдийн дүнг тухайн сумын нөөц боломж, онцлогт нийцүүлэн нэмэгдүүлж, бууруулан тооцсоны үндсэн дээр нийт 2,124.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 2-т харуулав/

1.1.7 Аймгаас сумдын татварын болон татварын бус орлогыг үндэслэлтэй хянасан эсэхийг аудитаар тулган баталгаажуулахад дараах сумдын суурь орлогыг сүүлийн 3 жилийн гүйцэтгэлд үндэслэлгүйгээр өндрөөр хянаж, баталсан байна. Үүнд:

- Орхон сум нь үйл ажиллагааны орлогыг нэмж төлөвлөсөн, аймгаас газрын төлбөрийн суурь орлогыг өндрөөр хянаж, баталсан,
- Алтанбулаг сумын хөрөнгийн болон ойн нөөцийн суурь орлогыг аймгаас өндрөөр хянаж, баталсан,
- Орхонтуул сум нь үйл ажиллагааны орлогыг нэмж төлөвлөсөн, аймгаас газрын төлбөрийн суурь орлогыг өндрөөр хянаж, баталсан,
- Түшиг сумын хөрөнгийн орлого, газрын болон ойн нөөц ашигласны төлбөрийн суурь орлогыг аймгаас өндрөөр хянаж, баталсан.

1.2 Орон нутгийн төсвийн зарлагыг холбогдох хууль эрхийн актуудад нийцүүлэн, үндэслэлтэй төлөвлөсөн эсэх?

Зураг төсөв, тооцоо судалгаа нь урьдчилан хийгдээгүй төсөл, арга хэмжээнүүдийг аймгийн ОНХО болон ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

1.2.1 Аймгийн ИТХ-ын 2024 оны 12 дугаар тогтоолоор 2025 оны аймгийн хянагдсан төсвийн нийт зарлагыг 6,914.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж, **83,837.2** сая төгрөгөөр /Дэлгэрэнгүйг хавсралт 3-т харуулав/ төлөвлөж, баталсан байна. Үүнд:

- Аймгийн ИТХ-ын зардлыг 417.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 1,121.2 сая төгрөгөөр,
- Аймгийн ИТХ-ын ГХУСАХЗ-ыг 550.0 сая төгрөгөөр бууруулан 710.0 сая төгрөгөөр,
- Аймгийн ЗДТГ-ын зардлыг 776.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 5,854.3 сая төгрөгөөр,
- ЗДНХ-ийн зардлыг 98.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 800.0 сая төгрөгөөр,
- БОГ-ын зардлыг 665.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 3,096.0 сая төгрөгөөр,
- Санхүүгийн хяналт аудитын албаны зардлыг 0.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 476.9 сая төгрөгөөр,
- ХААГ-ын зардлыг 47.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 387.7 сая төгрөгөөр,
- ОНӨГ-ын зардлыг 27.4 сая төгрөгөөр бууруулан 391.4 сая төгрөгөөр,
- Аймгийн халамжийн сангийн зардлыг 202.4 сая төгрөгөөр,
- Байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг 941.8 сая төгрөгөөр,
- Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг 1,246.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 2,229.3 сая төгрөгөөр,
- Улсын төсвийн байгууллагуудын төрийн албан хаагчдад олгох орон нутгийн нэмэгдлийг 318.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 2,258.0 сая төгрөгөөр,
- Улсын төсвийн байгууллагуудын тогтмол зардлыг 4,467.2 сая төгрөгөөр,
- ОНХО-ын зардлыг 3,552.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 11,306.7 сая төгрөгөөр,
- Аймгийн төсвөөс сумдад олгох санхүүгийн дэмжлэгийг 3,886.3 сая төгрөгөөр бууруулан 14,039.7.2 сая төгрөгөөр,
- ОНХС-ийн зарцуулалтыг улсын төсвөөс 31,299.0 сая төгрөгөөр хянаж ирүүлснийг өмнөх оны үлдэгдэл 2,068.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 33,367.3 сая төгрөгөөр,
- Улсын төсөвт төвлөрүүлэх зардлыг 2,187.4 сая төгрөгөөр гэх зэрэг.

1.2.2 Аймгийн ИТХ-ын 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 22 дугаар тогтоолоор “Сэлэнгэ аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө”-г 39 зорилт, 287 арга хэмжээтэйгээр баталсан байна.

1.2.3 Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.4, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Орон нутгийн төсөв нь Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх” гэж зохицуулсан байдаг.

1.2.4 Гэвч аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэхээр батлагдсан нийт 49 төсөл арга хэмжээний 3,361.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 23 төсөл, арга хэмжээ буюу нийт шинээр хэрэгжүүлэхээр баталсан төсөл, арга хэмжээний 47.4 хувь нь хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдаагүй байна.

1.2.5 Сумдын ИТХ-ын 2024 оны 12 дугаар сард хуралдсан хуралдаануудаар 2025 оны төсвийн нийт зарлагыг нийт **114,415.9** сая төгрөгөөр баталсан байна.

1.2.6 Тусгайлан зохицуулсан хууль, журам байхгүй атал Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар баталсан “Зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал”-д: “Мөрийн хөтөлбөрт тусгагдсан зарим арга хэмжээг хэрэгжүүлэх” /81518/ гэж тусгасныг үндэслэн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зардалд аймаг 2,229.3 сая төгрөг, Ерөө сум 158.0 сая төгрөг, Зүүнбүрэн сум 18.0 сая төгрөг, Жавхлант сум 25.0 сая төгрөг, Мандал сум 192.5 сая төгрөг,

Цагааннуур сум 9.6 сая төгрөг, Сайхан сум 37.0 сая төгрөг, Хүдэр сум 48.2 сая төгрөг, Түшиг сум 47.1 сая төгрөгийг тус тус холбогдох тооцоо судалгаа, нотлох баримтгүйгээр бөөн дүнгээр баталсан нь хөрөнгө худалдан авах, урсгал үйл ажиллагааг санхүүжүүлэх, тэтгэмж, шагнал олгох гэх мэтчилэн төсвийн цоорхойг нөхөхөд үрэлгэн байдлаар зарцуулах эрсдэлийг үүсгэсэн байна.

1.2.7 Зураг төсөв, үнийн тооцоо судалгаа нь урьдчилан хийгдээгүй 1,250.6 сая төгрөгийн 15 төсөл арга хэмжээг аймгийн ОНХО-ын эх үүсвэрээр, **4,431.9** сая төгрөгийн төсөвт өртөгтэй **16** төсөл арга хэмжээг /*аймгийн ОНХС 4,167.1 сая төгрөгийн 13 ТАХ*/ аймаг, сумдын ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр төлөвлөж, баталсан байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 4-т харуулав./

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана”, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 6 дугаар зүйлийн 6.3.3 дахь “хөрөнгө, оруулалтын төсөл хөтөлбөр арга хэмжээ нь хуульд заасны дагуу техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөв нь батлагдсан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдсэн, бусад зөвшөөрөлтэй байх”, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон байх” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

1.2.8 ОНХС-ийн чиг үүрэгт хамаарахгүй, төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжихгүй **2,477.4** сая төгрөгийн төсөвт өртөгтэй дараах 5 төсөл, арга хэмжээг аймгийн ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр баталсан байна. Үүнд:

- “Төрийн албан хаагчдын байр барих /Баруунбүрэн сум/” төсөл, арга хэмжээнд аймаг 200.0 сая төгрөг,
- Байрны фасад засвар /Мандал сум Спиртийн байр/ төсөл, арга хэмжээнд 528.0 сая төгрөг,
- 36, 45-р байрны фасад засвар /Мандал сум/ төсөл, арга хэмжээнд 147.3 сая төгрөг,
- Орон сууцны байрны дээврийн засвар /Сүхбаатар сум, 2-р баг/ төсөл, арга хэмжээнд 147.3 сая төгрөг,
- Төрийн албан хаагчийн байрны засвар /Мандал, Хэрх тосгон/ төсөл, арга хэмжээнд 400.0 сая төгрөг зэрэг.

Эдгээр Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24 дэх “төсвийн хөрөнгө оруулалт гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг”, 60 дугаар зүйлийн 60.3 дахь “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно”, 60.3.1: “орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр, арга хэмжээ”, Сангийн сайдын 2021 оны 86

дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.2.1-4.2.8 болон 4.4.1-4.4.9 дахь заалтуудыг зөрсөн байна.

1.2.9 Аймгийн ОНХО-аар улсын төсвийн байгууллагуудын өмчлөлд шилжих 165.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төсөвлөж, аймгийн ИТХ-аар батлуулсан нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24 дэх “хөрөнгө оруулалт гэж төсвөөс санхүүжүүлж, **тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг**” гэсэн заалтыг зөрчсөн байна. Үүнд:

- *Хилийн цэргийн алслагдсан ангиудын цахилгааны эх үүсвэр /Хилийн цэргийн 0243-р анги/ төсөл арга хэмжээнд 120.0 сая төгрөг,*
- *Шүүхийн тамгын газрын барилгын өргөтгөлийн засвар төсөл, арга хэмжээнд 45.0 сая төгрөг.*

1.2.10 Аймгийн ОНХО-аар хөрөнгө оруулалтын шинж чанартай бус хэт жижиглэсэн буюу байгууллагын урсгал зардалд тусган хэрэгжүүлэх боломжтой нийт 204.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 12 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн нь хөрөнгө оруулалтын мөн чанар, үр өгөөжийг буруулж, зорилго зорилтыг алдагдуулж байна.

1.2.11 Засаг даргын өргөн мэдүүлсэн төсвийн төсөлд тусгагдаагүй атал төлөөлөгчид санал гаргаж, хэлэлцэн, баталсан гэх үндэслэлээр аймаг ИТХ-д суудалтай 3 намд нэг суудлыг 5.0 сая төгрөгөөр тооцон нийт **205.0** сая төгрөгийг төлөвлөж, баталсан байна. Энэ нь Улс төрийн намын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх “*Нам дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно*”, 10.1.5: *Энэ хуулийн 34.6-д заасан хориглосон этгээдээс ... санхүүжилт шууд болон шууд бусаар авах*; 34.6.3: *Төрийн байгууллага болон нутгийн өөрөө удирдах байгууллага*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.3 Төсвийн жилийн дундуур орон нутгийн төсөвт тодотгол хийгдсэн эсэх?

Улсын төсөвт хийгдсэн тодотголыг үндэслэн ОНХО, ОНХС-ийн хөрөнгө оруулалтын зардлыг нийт 11,183.0 сая төгрөгөөр бууруулан тодотгосон байна.

1.3.1 УИХ-ын 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаар “Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулан Сэлэнгэ аймгаас улсын төсөвт шилжүүлэх орлогыг 6,477.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж 8,665.2 сая төгрөгөөр, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлгийг 8,242.9 сая төгрөгөөр бууруулж, 23,056.1 сая төгрөгөөр баталсныг үндэслэн аймгийн ИТХ-ын 2025 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 43 дугаар тогтоолоор дараах өөрчлөлтийг хийж, аймгийн 2025 оны төсвийн нийт орлого, зарлагыг тус бүр **4,803.6** сая төгрөгөөр бууруулж тодотгон **79,033.6** сая төгрөгөөр эцэслэн баталсан байна. */Дэлгэрэнгүйг хавсралт 1-д харуулав/*

Дүрслэл №1. Аймгийн тодотголын нэмэгдсэн, хасагдсан

/сая төгрөг/

Орлого:

Нэмэгдсэн

Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 4,595.5 сая төгрөг

Төсөвт байгууллагын өөрийн орлого 9.0 сая төгрөг

Сумдаас авах санхүүгийн дэмжлэг 3,205.5 сая төгрөг

Хасагдсан

ОНХС-д олгох орлогын шилжүүлэг 8,242.9 сая төгрөг

Төсвийн урьд оны үлдэгдэл 4,186.8 сая төгрөг

ОНХС-ийн эхний үлдэгдэл 183.9 сая төгрөг

Зардал:

Нэмэгдсэн

Улсын төсөвт төвлөрүүлэх орлого 6,477.8 сая төгрөг

ИТХ, ОНӨГ-ын урсгал зардал 98.2 сая төгрөг

Аймгийн ЗДНХ-ийг 400.0 сая төгрөг

Хасагдсан

Аймгийн ОНХО, ОНХС-ийн зардал 6,917.2 сая төгрөг

Сумдын ОНХС-д олгох шилжүүлэг 4,295.0 сая төгрөг

Сумдад олгох дэмжлэг 1,137.7 сая төгрөг

Хүснэгт №2. Аймгийн төсвийн эцэслэн тодотгож баталсан төлөвлөгөө

/сая төгрөг/

№	Үзүүлэлт	УИХ-аар баталсан дүн	2025 он	
			Анх баталсан	Тодотгол
А	Б	1	2	3
1	НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	79,109.8	83,837.2	79,033.6
2	УРСГАЛ ОРЛОГО	34,670.8	40,680.9	45,276.4
3	Татварын орлого	32,473.9	36,952.2	41,547.7
4	Татварын бус орлого	2,150.0	3,728.7	3,728.7
5	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас төвлөрүүлэх орлого	31,299.0	31,299.0	23,056.1
6	БУСАД ЭХ ҮҮСВЭР /Сумын төсвөөс аймгийн төсөвт төвлөрүүлэх орлого/	13,140.0	4,835.4	8,040.9
7	Байгууллагын өөрийн орлого	47.0	47.0	56.0
8	ӨМНӨХ ОНЫ ҮНДСЭН ТЭНЦЛИЙН АШИГ /өмнөх оны давсан орлогоос, хэмнэгдсэн зардлаас, мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс/	-	6,974.9	2,604.2
9	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	79,109.8	83,837.2	79,033.6
10	УРСГАЛ ЗАРДАЛ	19,943.2	22,936.1	24,004.7
11	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	13,704.4	14,039.7	12,902.0
12	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	43,274.9	44,674.0	33,461.7
13	Аймгийн төсвөөс улсын төсөвт шилжүүлэх орлого	2,187.4	2,187.4	8,665.2
14	НИЙТ ТЭНЦЭЛ	-	-	-

Эх сурвалж: Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

1.3.2 Аймгийн төсөвт тодотгол хийгдсэнтэй холбогдуулан сумдын ИТХ-аас тус тусын сумын төсөвт тодотгол хийж, анх батлагдсан төсвийг нийт **6,451.1** сая төгрөгөөр бууруулан **107,964.8** сая төгрөгөөр эцэслэн баталсан байна.

1.3.3 Дээд шатны төсөвт тодотгол хийгдсэн гэх үндэслэлээр улсын төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийг дагалдуулалгүйгээр зайлшгүй шаардлага үүсээгүй байхад сумдын урсгал зардлыг **85.9** сая төгрөгөөр нэмэгдүүлэн төсвийн тодотгол хийсэн байна. Үүнийг графикаар харуулбал:



Эх сурвалж: Сумдын ИТХ-ын төсөв баталсан тогтоолууд

Энэ нь Төсвийн тухай хуулийн 34 дугаар зүйлийн 34.2 дахь “Засаг дарга дараах тохиолдолд тухайн жилийн төсвийн тодотголыг боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ”, 34.2.2: “Урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, зарлага нэмэгдэж, орон нутгийн **төсөв алдагдалтай болох** нөхцөл байдал бий болсон” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.3.4 Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1, 42.2.2 дахь заалтын дагуу аймгийн Засаг даргын захирамжаар 5 удаа, сумдын Засаг даргын захирамжаар тус бүр 1-4 удаа төсвийн зохицуулалт хийсэн байна.

БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫГ БҮРЭН ТӨВЛӨРҮҮЛСЭН ҮҮ?

2.1 Татварын ба татварын бус орлогыг нэмэгдүүлэх нөөц боломжийг бүрэн ашиглаж, төлөвлөсөн орлогыг бүрэн төвлөрүүлсэн эсэх?

Ногдол ашгийн орлого, сүү, ноос, ноолуур, хүнсний ногооны урамшуулал олгогдоогүйгээс 9 сумын төсвийн орлогын төлөвлөгөө 1,144.2 сая төгрөгөөр тасарсан байна.

2.1.1 Аймаг, сумдын татварын болон татварын бус орлогыг **105,512.3** сая төгрөгөөр эцэслэн төлөвлөснөөс гүйцэтгэлээр **118,166.3** сая төгрөгийг төвлөрүүлж, **112.0** хувийн биелэлттэй тайлагнагдсан байна.

Хүснэгт №3. Аймаг, сумдын төсвийн орлогын гүйцэтгэл

/сая төгрөг/

Орлогын нэр төрөл	2024 оны гүйцэтгэл	2025 он							
		Аймаг		Сумд		Нийт орлого			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татварын орлого	84,111.5	41,547.7	52,446.4	55,709.4	59,361.6	97,257.1	111,807.9	(14,550.8)	115.0
ХХОАТ-ын	43,756.2	-	103.1	47,222.1	50,144.9	47,222.1	50,248.0	(3,025.9)	106.4
ХХОАТ-ын буцаалт	(2,193.8)	-	-	(2,633.6)	(2,642.6)	(2,633.6)	(2,642.6)	9.0	100.3

ААНОАТ	26,181.0	33,325.5	46,665.9	-	-	33,325.5	46,665.9	(13,340.4)	140.0
Хөрөнгийн албан татвар	5,088.6	1,153.0	1,212.9	4,162.4	4,466.2	5,315.4	5,679.1	(363.7)	106.8
Бусад татвар, төлбөр, хураамж	11,279.5	7,069.2	4,464.5	6,958.5	7,393.1	14,027.7	11,857.5	2,170.1	84.5
Татварын бус орлого	6,377.8	3,728.7	1,590.4	4,526.5	4,769.2	8,255.2	6,358.4	1,896.8	77.0
Хүү, торгуулийн орлого	3,675.6	1,000.0	851.8	2,710.4	3,178.6	3,710.4	4,030.4	(320.0)	108.6
Бусад орлого	2,463.2	2,578.7	626.3	1,806.7	1,579.5	4,385.4	2,205.8	2,179.6	50.3
Түрээсийн орлого	10.5	-	-	9.4	9.9	9.4	9.9	(0.5)	104.9
Хөрөнгө борлуулсны орлого	228.5	150.0	112.3	-	-	150.0	112.3	37.7	74.9
НИЙТ ОРЛОГО	90,489.3	45,276.4	54,036.8	60,235.9	64,129.5	105,512.3	118,166.3	(12,654.0)	112.0

Эх сурвалж: Аймаг, сумдын ИТХ-ын тодотгосон төсөв баталсан тогтоолууд, аймгийн ТЕЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1.2 Аймгийн татварын болон татварын бус орлогын төлөвлөгөө 8,760.4 сая төгрөгөөр давж биелсэн нь ААНОАТ-ын орлого 40.0 хувиар буюу 13,340.0 сая төгрөгөөр давсан нь голлон нөлөөлсөн байна.

2.1.3 Сумд татварын болон татварын бус орлогын төлөвлөгөөг 6.5 хувиар буюу 3,893.7 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн бөгөөд аймгийн төсвөөс 12,901.9 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авсан байна.

Хүснэгт №4. Сумдын тодотгосон төсвийн орлогын гүйцэтгэл, санхүүгийн дэмжлэг

/сая төгрөг/

Д/д	Сумын нэр	Сумдын тодотгосон төсвийн орлого				Санхүүгийн дэмжлэг		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	Алтанбулаг	1,322.3	1,189.6	132.7	90.0	764.4	764.4	100.0
2	Баруунбүрэн	1,292.2	1,140.8	151.4	88.3	917.4	917.4	100.0
3	Баянгол	2,563.1	3,001.9	(438.8)	117.1	32.4	32.4	100.0
4	Ерөө	9,410.1	10,075.0	(664.9)	107.1	-	-	-
5	Жавхлант	711.6	590.8	120.8	83.0	1,557.2	1,557.2	100.0
6	Зүүнбүрэн	697.3	719.7	(22.4)	103.2	1,118.3	1,118.3	100.0
7	Мандал	12,359.1	14,083.1	(1,724.0)	113.9	-	-	-
8	Орхон	1,014.3	840.9	173.4	82.9	933.8	933.8	100.0
9	Орхонтуул	1,157.9	1,068.9	89.0	92.3	1,580.3	1,580.3	100.0
10	Сайхан	6,290.5	6,416.3	(125.8)	102.0	-	-	-
11	Сант	684.6	705.0	(20.4)	103.0	1,252.0	1,252.0	100.0
12	Сүхбаатар	14,203.2	16,065.6	(1,862.4)	113.1	-	-	-
13	Түшиг	931.0	823.8	107.2	88.5	1,207.6	1,207.6	100.0
14	Хушаат	767.5	766.0	1.5	99.8	929.0	929.0	100.0
15	Хүдэр	3,656.9	3,319.9	337.0	90.8	0.0	0.0	-
16	Цагааннуур	1,801.5	1,769.0	32.5	98.2	1,011.8	1,011.8	100.0
17	Шаамар	1,372.8	1,553.2	(180.4)	113.1	1,597.7	1,597.7	100.0
	Дүн	60,235.9	64,129.5	(3,893.7)	106.5	12,901.9	12,901.9	100.0

Эх сурвалж: Сумдын ИТХ-ын тогтоол, Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

Сумдын орлогын төлөвлөгөөний давсан болон тасарсан орлогыг нэр төрлөөр авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд.

Сумдын төсвийн давж биелсэн орлогууд:

- Цалин хөлс, шагнал урамшуулал тэдгээртэй адилтах орлого: Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосон, өмнөх оны ХХОАТ-ын өглөгийг барагдуулсантай холбоотойгоор 3,886.4 сая төгрөгөөр,
- Торгуулийн орлого: Тайлант онд хувь хүний хариуцлагын асуудалтай холбоотой торгууль ихээр бичигдсэнээс шалтгаалан 468.2 сая төгрөгөөр,
- Малын тоо толгойн албан татварын орлого: Өмнөх оны өр төлбөрийг барагдуулсантай холбоотойгоор 228.8 сая төгрөгөөр,
- Улсын тэмдэгтийн хураамж: Иргэдийн төрийн үйлчилгээ авах нь нэмэгдэж, бүртгэл болон хураамжийн орлого өссөнтэй холбоотойгоор 59.9 сая төгрөгөөр,
- Дуудлага худалдааны орлого: Тайлант онд иргэн, аж ахуйн нэгжид дуудлага худалдаагаар газар олголт нэмэгдсэнтэй холбоотойгоор 136.5 сая төгрөгөөр,
- Ойн нөөц ашигласны төлбөр: Түлшний мод бэлтгэх эрхийг нэмэгдүүлсэн, Баруунбүрэн суманд самар бэлтгэх дуудлага худалдааг зохион байгуулсан, Ерөө сумаас мод шилжүүлэн суулгах төлбөр төвлөрсөн зэргээс 503.2 сая төгрөгөөр тус тус давж биелсэн байна.

Төлөвлөгөө тасарсан орлогууд:

- Бусад орлого: Хүдэр, Баруунбүрэн суманд самрын нөөц бага тогтоогдсон, төлөвлөгөөт хяналт шалгалтаар зөрчил илрээгүй зэргээс шалтгаалан 227.2 сая төгрөгөөр,
- Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр: Тайлант онд хур тунадас бага, ган, түймэр их гарснаас ургамал, хадлангийн ургац муу байсантай холбоотойгоор 46.9 сая төгрөгөөр,
- Хог хаягдлын үйлчилгээний хураамж: Айл өрхүүдийн хогны хураамжийн төлөлт бага, төлөвлөсөн орлогыг бүрэн төвлөрүүлээгүй зэргээс шалтгаалан 61.5 сая төгрөгөөр,
- Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр: Тайлант онд Мандал сумын төлөвлөгөөг үндэслэлгүйгээр хэт өндөр төлөвлөсөн, Баруунбүрэн сумын ИТХ-аар төлбөрийн хэмжээг Засгийн газрын тогтоолоос өндрөөр тооцсоноос шалтгаалж, илүү төлөвлөсөн, Хушаат суманд хийгдэхээр төлөвлөсөн замын ажлын элс, хайрга дайргыг Дархан-Уул аймгаас бэлтгэсэнээс шалтгаалан тус орлого 200.6 сая төгрөгөөр,
- Хөрөнгийн орлого: Иргэдийн харилцах, хадгаламжийн үлдэгдэл буурсан, ногдол ашгийн орлого төлөвлөсөн хэмжээнээс бага төвлөрснөөс шалтгаалан 337.8 сая төгрөгөөр,
- Үйл ажиллагааны орлого: Сүү, ноос, ноолуур, хүнсний ногооны урамшуулал тайлант онд олгогдоогүй, мөн орлогын төлөвлөгөөг өндрөөр баталсантай холбоотойгоор 660.8 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

2.1.4 Дараах сумд татварын болон татварын бус орлогын төлөвлөгөөг 536.2 сая төгрөгөөр тасалсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 дэх “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна. Тодруулбал:

Дүрслэл №3: Төсвийн орлогын төлөвлөгөө тасалсан сумд



2.2. Төсөвт байгууллагуудын төлөвлөсөн өөрийн орлогыг бүрэн төвлөрүүлж, нөөц боломжийг ашигласан эсэх?

Өөрийн орлогыг ойн ангиуд үндэслэлгүй төлөвлөснөөс 72.0 сая төгрөгийн орлого нэмэгдүүлэх нөөц боломжийг алдсан байна.

2.2.1 Тайлант онд орон нутгийн төсөвт байгууллагууд өөрийн орлогыг 379.7 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 527.4 сая төгрөг төвлөрч, төлөвлөгөөг 38.9 хувиар буюу 147.7 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт №5. Төсөвт байгууллагуудын өөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөг/

д/д	Сумын нэр	Байгууллагын нэр	2025 он			
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Сэлэнгэ	Аймгийн ЗДТГ	45.00	54.23	9.23	120.5
2	Сэлэнгэ	Аймгийн Худалдан авах ажиллагааны газар	11.00	12.11	1.11	110.1
3	Алтанбулаг	ЗДТГ	0.50	3.09	2.59	6 дахин
4	Баруунбүрэн	ЗДТГ	43.70	37.25	(6.45)	85.2
		Орхон бүсийн ойн анги	20.00	33.34	13.34	166.7
5	Баянгол	ЗДТГ	5.00	4.09	(0.91)	81.8
6	Ерөө	ЗДТГ	0.50	30.93	30.43	61 дахин
		Бугант Захирагчийн алба	5.00	1.80	(3.20)	36.0
		Ойн анги	75.00	75.05	0.05	100.1
7	Жавхлант	ЗДТГ	0.80	0.80	-	100.0
8	Зүүнбүрэн	ЗДТГ	5.21	7.27	2.06	139.5
9	Мандал	Түнхэл Захирагчийн алба	6.48	4.22	(2.26)	65.1
		Ойн анги	60.00	99.54	39.54	165.9
10	Орхон	ЗДТГ	0.50	1.92	1.42	3 дахин
11	Орхонтуул	ЗДТГ	0.50	0.50	-	100.0
12	Сант	ЗДТГ	5.00	12.86	7.86	257.2
13	Сүхбаатар	ЗДТГ	0.00	4.80	4.80	48 дахин
		Ойн анги	0.03	24.88	24.86	99 дахин
14	Түшиг	ЗДТГ	0.50	0.50	-	100.0
15	Цагааннуур	ЗДТГ	4.90	4.90	-	100.0
		Ойн анги	51.53	67.77	16.24	131.5
16	Шаамар	ЗДТГ	14.26	19.85	5.59	139.2

	Дулаанхаан тосгоны захирагчийн алба	24.25	25.68	1.43	105.9
Нийт дүн		379.66	527.38	147.72	138.9

Эх сурвалж: Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.2.2 Түрээсийн орлогыг бүрэн төвлөрүүлээгүйгээс Баянгол, Баруунбүрэн сумын ЗДТГ, Ерөө сумын Бугант, Мандал сумын Түнхэл тосгоны Захирагчийн алба зэрэг байгууллагууд нь өөрийн орлогын төлөвлөгөөг нийт 12.8 сая төгрөгөөр тасалж, орлого төвлөрүүлэх нөөц боломжийг алдсан бол 15 байгууллага 160.5 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

2.2.3 Сүхбаатар сумын ЗДТГ болон Ойн ангийн өөрийн орлогын төлөвлөгөөг сумын ИТХ-аар батлуулахдаа орон андуурсны улмаас 0.02 сая төгрөгөөр /26.5 сая төгрөгийг/ буюу 26.4 сая төгрөгөөр дутуу батлуулсан байна.

2.2.4 Үйл ажиллагааны өөрийн орлогыг сүүлийн 3 жилийн гүйцэтгэлийн дунджаар тооцон төлөвлөхөөр зохицуулагдсан атал дараах ойн ангиуд нийт 72.0 сая төгрөгөөр дутуу төлөвлөж орлого нэмэгдүүлэх нөөц боломжийг ашиглаагүй байна. Үүнд:

- Баруунбүрэн сумын Ойн анги 8.9 сая төгрөгөөр,
- Ерөө сумын Ойн анги 25.0 сая төгрөгөөр,
- Мандал сумын Ойн анги 28.8 сая төгрөгөөр,
- Цагааннуур сумын Ойн анги 9.3 сая төгрөгөөр.

БҮЛЭГ 3. БАТЛАГДСАН ТӨСВИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ, ҮР ДҮНТЭЙ ЗАРЦУУЛСАН УУ?

3.1 Орон нутгийн төсвийн зарлагын гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан бодитой, үнэн зөв эсэх?

Аймаг, сумдын дүнгээр төсвийн зарлагын төлөвлөгөө 78.2 хувийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан байгаа нь ОНХО, ОНХС-ийн хэмнэлтээс голлон шалтгаалсан байна

3.1.1 Сэлэнгэ аймгийн 2025 оны төсвийн нийт зарлагыг 150,538.1 төгрөгөөр /сумдын ИТХ-аар баталсан дүн орсон/ баталснаас 117,668.6 төгрөгийн буюу 78.2 хувийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан нь өмнөх оны гүйцэтгэлээс 7,951.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6. Нийт зарлагын гүйцэтгэл

/сая төгрөг/

Код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	2025 он			
			Тодотгон баталсан	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
А	Б	1	2	3	4=3-2	5
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	109,717.0	150,538.1	117,668.6	(32,869.5)	78.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	71,797.2	99,840.9	80,653.1	(19,187.8)	80.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	66,045.7	86,989.4	77,095.9	(9,893.5)	88.6
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	24,739.2	31,631.9	29,379.0	(2,252.9)	92.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,056.1	4,035.6	3,567.1	(468.5)	88.4

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,845.7	24,110.4	21,829.2	(2,281.2)	90.5
2104	Хангамж, бараа материалын зардал	1,483.9	1,635.7	1,235.8	(399.9)	75.6
2105	Нормативт зардал	23.1	41.9	22.3	(19.6)	53.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,828.5	3,989.1	3,501.7	(487.4)	87.8
2107	Томилолт, зочны зардал	451.0	570.3	421.7	(148.6)	73.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,344.3	9,432.3	7,643.5	(1,788.8)	81.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,273.9	11,542.2	9,495.6	(2,046.6)	82.3
212	ТАТААС	125.9	308.0	257.1	(50.9)	83.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,625.6	12,543.5	3,300.1	(9,243.4)	26.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	37,556.4	47,246.2	36,063.2	(11,183.0)	76.3
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	363.4	3,451.0	952.5	(2,498.5)	27.6


Эх сурвалж: Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

3.1.2 Орон нутгийн төсвийн нийт зарлагыг эдийн засгийн ангиллаар нь задалж үзвэл бараа, ажил үйлчилгээний зардал 88.6 хувийн, урсгал шилжүүлэг 26.3 хувийн, хөрөнгийн зардал 76.3 хувийн, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 27.6 хувийн гүйцэтгэлтэй буюу нийт 32,869.3 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна.

3.1.3 Нийт төсвийн зарлагын 30.6 хувийг хөрөнгийн зардал, 28.0 хувийг цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, 18.6 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, 2.8 хувийг урсгал шилжүүлгийн зардал, 0.8 хувийг эргэж төлөгдөх цэвэр зээл, 19.2 хувийг бусад зардал эзэлж байна.

Дүрслэл №4: Орон нутгийн төсвийн нийт зарлагын бүтэц

/сая төгрөг/



3.1.4 Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 117,668.6 сая төгрөг буюу 78.2 хувьтай байгаа нь хөрөнгийн зардлыг 11,183.0 сая төгрөгөөр, урсгал зардлыг 19,188.0 сая төгрөгөөр, эргэж төлөгдөх зээлийг 2,498.5 сая төгрөгөөр тус тус хэмнэснээс шалтгаалсан байна. Үүнд:

- Цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, ажил олгогчийн НДШ-ийн зардал нийт 2,721.4 сая төгрөгөөр,
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 2,281.2 сая төгрөгөөр,
- Хангамж бараа материалын зардал 399.9 сая төгрөгөөр,
- Нормативт зардал 19.6 сая төгрөгөөр,
- Эд хогшил, урсгал засварын зардал 487.4 сая төгрөгөөр,
- Албан томилолтын зардал 148.6 сая төгрөгөөр,

- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 1,788.8 сая төгрөгөөр,
- Бараа үйлчилгээний бусад зардал 2,046.6 сая төгрөгөөр гэх мэт.

3.1.5 Аймаг, сумдын төсвийн байгууллагуудын бараа, ажил үйлчилгээний зардалд 86,989.4 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 77,095.9 сая төгрөгийг олгож, 9,893.5 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь Засгийн газраас зардлыг хэмнэх, хэрэгжүүлж буй хөтөлбөр, арга хэмжээг хэмнэлтийн горимоор үргэлжлүүлэх шийдвэр гарснаар Сангийн яам зарцуулах эрхийг хязгаарласан нь голлон нөлөөлсөн байна.

3.1.6 Тайлант онд ОНХО, ОНХС, Замын сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл, арга хэмжээнд 47,246.2 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 36,063.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, 11,183.0 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-д “*батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах;*” гэж заасны дагуу худалдан авах ажиллагааг тус хугацаанаас өмнө зохион байгуулж, гэрээ байгуулаагүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийг хэмнэлтэд тооцсоноос голлон шалтгаалсан байна.

3.2 Батлагдсан төсвийг холбогдох хууль, эрхийн актын хүрээнд зориулалтын дагуу зарцуулсан эсэх?

Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө болон үйл ажиллагааны хөтөлбөрийн зардлаас хөрөнгө оруулалтын шинжтэй төсөл, арга хэмжээг санхүүжүүлсэн байна.

3.2.1 Аймгийн ТЕЗ, түүний харьяа байгууллагууд нь батлагдсан төсвийг зардлын хөтөлбөр болон бүлэг хооронд гүйлгэн зориулалт бусаар зарцуулсан 13 сумын нийт **87.3 сая** төгрөгийн зөрчил илэрсэн байна. *Аймаг, сумдын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар зөрчлөөр тооцогдож, албан шаардлага хүргүүлсэн/*

3.2.2 Аймаг, сумдын Засаг даргын нөөц хөрөнгийн батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан нийт **182.6 сая** төгрөгийн зөрчил илэрсэн байна. Үүнд:

- *Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн батлагдсан төсвөөс жил бүр тогтмол гардаг, урьдчилан төлөвлөх боломжтой, аймгийн ЗДТГ-ын болон бусад байгууллагын урсгал төсөвт тусган хэрэгжүүлэх боломжтой Дөл тэмцээн, хүндэт жуух бичиг хэвлүүлэх, ургацын баяр, улсын төсвийн байгууллагуудад хөрөнгө авч өгөх зэрэг үйл ажиллагаанд нийт **113.6 сая төгрөг,***
- *Сумд тохижилт, үйлчилгээний зардал, ойн тэмдэглэх болон баярын үйл ажиллагаа, сургалт зөвлөгөөн, цэрэг татлага зэрэг үйл ажиллагаанд нийт **69.0 сая төгрөг** гэх мэт.*

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “*Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам*”-ын 2.1.5 дахь “*энэ журмын 2.1.1, 2.1.2-т зааснаас бусад Засаг дарга хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээ*”,

3.1.2 дахь “урьдчилан төлөвлөх боломжтой гадаад, дотоод албан томилолтын зардал, энэ журмын 2.1.1, 2.1.2-т зааснаас бусад зориулалтаар тоног төхөөрөмж бэлтгэх хөрөнгө оруулалтын зардлыг тусгаагүй байх” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

3.2.3 Дараах байгууллагууд батлагдсан төсвийг үр ашиг, арвилан хэмнэлтгүй зарцуулсан 14.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Үүнд:

- *Аймгийн ЗДТГ нь тухайн байгууллагад байгууллагад ажилладаггүй 4 иргэнд /Л.Довчинбазар, Г.Сэржмядаг, Б.Отгонбаасан, Д.Лувсандагва/ нэг удаагийн тэтгэмж, урамшууллын батлагдсан төсвөөс 0.9 сая төгрөгийг зарцуулсан,*
- *Мандал сум нь баяр наадмын зардлыг 3.1 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан,*
- *Хүдэр сум нь байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас зах зээлийн бодит үнээс 10.0 сая төгрөгөөр илүү дүнгээр автомашин худалдан авсан гэх мэт.*

3.2.4 Зарцуулалтыг нь хууль, эрхийн актаар зохицуулаагүй аймаг, сумдын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлын төсвөөс улсын болон орон нутгийн төсөвт байгууллагуудад техник, тоног төхөөрөмж, хөрөнгө худалдан авах болон урсгал зардалд нийт 150.0 сая төгрөгийг зарцуулсан байна. Үүнд:

- *Аймгийн ТЕЗ нь 122.0 сая төгрөг,*
- *Мандал, Хушаат сумд нь нийт 28.0 сая төгрөг.*

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ын холбогдох заалтуудыг зөрчсөн байна.

3.2.5 Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулаагүй 146.4 сая төгрөгийн дараах зөрчлүүдийг санхүүгийн тайлангийн аудитын зөрчлөөр тооцож, албан шаардлага хүргүүлсэн байна. Үүнд:

- *“Цагааннуур тохижилт” ОНӨААТҮГ нь тайлант онд 30.0 сая төгрөгийн шатахууны худалдан авалтыг тендер зарлалгүйгээр шууд гэрээ байгуулсан,*
- *“Гавшгай Ус” ОНӨААТҮГ нь 88.6 сая төгрөгийн худалдан авалтыг хуулийн дагуу зохион байгуулаагүй,*
- *“Илдэн бүрэн” ОНӨААТҮГ нь шууд худалдан авах босго үнээс давсан 27.8 сая төгрөгийн нүүрсний худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй гэх мэт.*

Эдгээр нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 10 дугаар зүйлийн 10.2, 10.3, 35 дугаар зүйлийн 35.2, 54 дүгээр зүйлийн 54.8, Засгийн газрын 2024 онд батлагдсан “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоолын хавсралтын 1-д заасныг тус тус зөрчсөн байна.

3.2.6 Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан,

төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл"-ийн хүрээнд ТЕЗ-ийн харьяа байгууллагуудаас авсан судалгааны үр дүн дараах байдалтай байна. Үүнд:

1.Унаа, хоолны хөнгөлөлттэй холбоотой:

Аймгийн ТЕЗ-ийн харьяа 30 байгууллагын төсөвт холбогдох тушаал шийдвэрийг үндэслэн нэг хүнд ногдох 1 өдрийн хөнгөлөлтийн тарифыг дийлэнх буюу 24 байгууллага нь 3.0–10.0 мянган төгрөгөөр тооцож, баталсан бол аймгийн ИТХ, Сүхбаатар сумын ЗДТГ, ИТХ нь 20.0 мянган төгрөгөөр, аймгийн ЗДТГ, БОГ нь 30.0 мянган төгрөгөөр, Бэлчир бүсийн сум дундын ойн анги нь 35.0 мянган төгрөгөөр тус тус баталж, нийт 1,274.7 сая төгрөгийн нэмэгдлийг олгохоор тооцон төлөвлөж, гүйцэтгэлээр 1,459.6 сая төгрөгийг олгосон байна.

2.Гадаад томилолт, арга хэмжээтэй холбоотой:

3 байгууллага эрх бүхий этгээдээс баталсан шийдвэрийн дагуу хамтран ажиллах гэрээ байгуулах, санамж бичиг солилцох, ажилтан солилцох, оюутан, сурагч сургах, туршлага судлах, хурал, үзэсгэлэн яармагт оролцох зэрэг 28 арга хэмжээнд 298.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

3.Төрд учирсан хохиролтой барагдуулахтай холбоотой:

2 байгууллага ажлаас үндэслэлгүй халагдсаны цалин, НДШ, томилолтын зардалд 10.1 сая төгрөгийг байгууллагын төсвөөс барагдуулан, 6.5 сая төгрөгийг авлагаар, 3.6 сая төгрөгийг зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн боловч буруутай албан тушаалтнаар хохирлыг нөхөн төлүүлээгүй байна.

5.Сургалт, семинар, хурал зөвлөгөөнд зарцуулсан зардалтай холбоотой:

31 байгууллага эрх бүхий этгээдээс баталсан шийдвэрийн дагуу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, архив, бичиг хэргийн ажилтны, төрийн албан хаагчид болон ИТХ-ын төлөөлөгчдийг чадавхжуулах, ИТХ-ын хуралдааны зардал зэрэг 126 арга хэмжээнд 215.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

6.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдтэй холбоотой:

22 ОНӨҮГ нь тайлант онд 481 орон тоотойгоор ажиллаж, 6,370.6 сая төгрөгийн цалин, нэмэгдэл олгосон бөгөөд санхүүгийн тайланд 3,576.3 сая төгрөгийн дүрмийн сан, 63,333.1 сая төгрөгийн хөрөнгө, 4,431.6 сая төгрөгийн өр төлбөр, 92.8 сая төгрөгийн найдваргүй болон олон жилийн насжилттай авлага, 28,511.4 сая төгрөгийн орлого, 34,048.6 сая төгрөгийн зардал, 4,835.4 сая төгрөгийн алдагдал тус тус тайлагнагдсан байна.

7.Орон тоо, цалингийн сантай холбоотой:

Сангийн яамнаас гэрээт ажилтны тоог оруулалгүйгээр Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын орон тоог 700 албан хаагчаар баталж, төсвийн тодотголоор 9.0 хувиар буюу 64 албан хаагчаар бууруулан 636 албан хаагчаар хянаж, ирүүлсэн байна.

Судалгааны үр дүнгээр тайлант онд 52 байгууллагаас /орон нутгийн өмчит 22 байгууллага, сумдын ойн ангийг хасаж тооцов/ нийт 841 орон тоонд 31,710.2 сая төгрөгийн цалингийн сан батлагдсанаас, тайлант онд хийгдсэн төсвийн тодотголоор 4 байгууллагын удирдах 2, гүйцэтгэх 10, үйлчилгээний 3 зэрэг нийт 15 орон тоог бууруулан 826 орон тоогоор эцэслэн баталсан байна. Үүнд:

- Сэлэнгэ аймгийн ЗДТГ нь 9,
- БОГ нь 3,
- Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь 2,
- Жавхлант сумын ИТХ нь 1 орон тоог тус тус бууруулсан байна.

Гүйцэтгэлээр нийт 718 албан хаагчийн цалингийн зардалд 29,379.0 сая төгрөгийг зарцуулсан нь орон тоо дутуу ажилласантай холбоотой байгаа бөгөөд ажлын байрны чиг үүргийн давхардлыг тооцох орон тооны шинжилгээ хийгдээгүй, цомхотголд орсон албан хаагчдад олгох тэтгэмжийн санхүүжилтийг төсөвт тусгаагүй зэрэг нь тус шийдвэр орон нутагт бодитой хэрэгжих боломжгүй нөхцөл байдлыг үүсгэж байна.

8.Хэвлэл мэдээллийн байгууллагатай холбоотой:

Аймгийн ЗДТГ, ИТХ, Байгаль орчны газрууд нь цаг үеийн мэдээ, мэдээллийг сонин, ТВ, фэйж, цахим хуудсаар түгээхээр 7 хэвлэл мэдээллийн байгууллага, иргэнтэй нийт 31.3 сая төгрөгийн гэрээ байгуулж, 21.4 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

3.3 ОНХС, ОНХО-аар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжсэн эсэх?

Аймаг, сумын ОНХО болон ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт төсөл, арга хэмжээний 80.1 хувь нь бүрэн хэрэгжсэн байна.

Дүрслэл №5: Аймгийн ОНХО, ОНХС-ийн хэрэгжилт

/сая төгрөг/



3.3.1 Тайлант онд аймгийн хөрөнгө оруулалтаар нийт 9,006.3 сая төгрөгийн 83 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, баталснаас 7,151.9 сая төгрөгийн 71 төсөл арга хэмжээ бүрэн, 816.7 сая төгрөгийн 2 арга хэмжээ дутуу хэрэгжиж, 1,037.7 сая төгрөгийн 10 төсөл, арга хэмжээ огт хэрэгжээгүй байна.

3.3.2 Аудитаар аймгийн ОНХО-ын хөрөнгөөр хэрэгжүүлсэн 110.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Сумдад төрийн үйлчилгээний киоск машин” төсөл, арга хэмжээний 3.3 сая төгрөгийн гүйцэтгэлийн баталгааг банкны болон даатгалын байгууллагаар баталгаажуулалгүйгээр гэрээ байгуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх “Тендер шалгаруулалтын төсөвт өртөг 100 сая төгрөгөөс дээш бол гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гүйцэтгэлийн баталгаа шаардана” гэсэн заалтыг зөрчсөн байна.

3.3.3 Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 18,229.9 сая төгрөгийн 57 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, баталснаас 10,431.7 сая төгрөгийн 35 төсөл арга хэмжээ бүрэн, 4,389.8 сая төгрөгийн 7 төсөл, арга хэмжээ дутуу хэрэгжиж, 3,408.4 сая төгрөгийн 15 төсөл арга хэмжээ огт хэрэгжээгүй байна.

3.3.4 Сумдын ОНХС, ОНХО-аар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

Дүрслэл №6: Сумдын ОНХО, ОНХС-ийн хэрэгжилт



Эх сурвалж: Сумдын ИТХ-ын тогтоол, ТТЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

3.3.5 Сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан төсөл, арга хэмжээний 74.2 хувь буюу 13,070.2 сая төгрөгийн 204 төсөл, арга хэмжээ бүрэн, 8,261.5 сая төгрөгийн 24 төсөл, арга хэмжээ дутуу хэрэгжсэн бол 2,433.9 сая төгрөгийн 47 төсөл, арга хэмжээ огт хэрэгжээгүй байна.

3.3.6 Сумын ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлтэй холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна /Сумдын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитад зөрчлөөр тооцсон/. Үүнд:

- Жавхлант сум нь магадалшгүй ажлын хурлын тэмдэглэл, төсөв, гүйцэтгэсэн ажлын зураг зэрэг анхан шатны баримтгүйгээр 4 төсөл арга хэмжээнд /малын

худгийн хашаа, орон нутгийн өмчит байгууламжуудын засвар, ухаалаг худаг, ус цэвэршүүлэх байгууламж, ЕБС-ийн дээврийн засвар/ 4.2 сая төгрөгийн магадалшгүй ажлын зардал олгосон,

- Мандал сум нь “Түнхэл тосгонд тоглоомын талбай байгуулах (Наадмын талбай) 5-р баг” төсөл, арга хэмжээний санхүүжилт 9.7 сая төгрөгийг гүйцэтгэгч Баян өргөн уул ХХК-д илүү олгосон,
- Мандал сум нь ОНХО-ын батлагдсан төсвөөс хэрэгжүүлсэн “1-р багийн стадионы баруун талын задгай хэсгийн шинэ суурьшлын бүсийн цахилгаан хангамж” төсөл, арга хэмжээний санхүүжилт 55.4 сая төгрөгийг ОНХС-ийн батлагдсан төсвөөс гүйцэтгэгч Нарсан цамхаг ХХК-д шилжүүлсэн,
- Сант сум нь 618.5 сая төгрөгийн 16 төсөл, арга хэмжээнээс удирдлага мэдээллийн системд 11 төсөл арга хэмжээний 112.5 сая төгрөгийн төсөл, арга хэмжээний мэдээллийг дутуу оруулсан,
- Сүхбаатар сум нь өмнөх оноос хэрэгжиж эхэлсэн “Сүхбаатар сумын гудамж талбайд камержуулалт хийх” 385.0 сая төгрөгийн гэрээний дүн бүхий төсөл, арга хэмжээний явцын санхүүжилтийг “Гэрээний тусгай нөхцөл”-д заасан 70 хувиар бус 38.5 сая төгрөгийг илүү олгосон,
- Хушаат сум нь бүрэн хэрэгжсэн 3 төсөл, арга хэмжээний гэрээнд тусгагдсан 5 хувийн чанарын баталгаа буюу 11.4 сая төгрөгийг суутган тооцолгүй, гүйцэтгэгчид шилжүүлсэн,
- Цагааннуур сум нь харьцуулалтын аргаар тендер шалгаруулалтыг зохион байгуулахаас зайлсхийж гэрээ шууд байгуулах аргын босго үнэд багтаах зорилгоор 76.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий зураг төсвийн ажлыг сумын төвийн явган хүний зам, дугуйн зам, хатуу хучилттай зам зэрэг зураг төсвийн 4 төсөл, арга хэмжээ болгон төлөвлөсөн байна.

3.3.7 Сумдын ОНХО-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан төсөл, арга хэмжээний 76.8 хувь буюу 12,066.3 сая төгрөгийн 86 төсөл, арга хэмжээ бүрэн, 1,963.7 сая төгрөгийн 9 төсөл, арга хэмжээ дутуу хэрэгжсэн байна.

3.3.8 Сумын ОНХО-ын эх үүсвэрээр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлтэй холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна /Сумдын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитад зөрчлөөр тооцсон/. Үүнд:

- Баянгол сум нь орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 2 төсөл арга хэмжээний 1.7 сая төгрөгийн магадалшгүй ажлын зардлыг акт, хурлын тэмдэглэл, төсөв зэрэг анхан шатны баримтгүй олгосон,
- Шаамар сумын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад батлагдсан “Бохир соруулах машин” төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаанд “Монтир транс ХХК” нь 67.9 сая төгрөгөөр шалгарсан боловч бичиг хэргийн ажилтны буруугаас шалтгаалан мөнгөн дүнг буруу тооцон, гэрээг 69.5 сая төгрөгөөр байгуулан 1.6 сая төгрөгийг гүйцэтгэгчид илүү шилжүүлсэн байна.

ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ

Сэлэнгэ аймгийн 2025 оны төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлд хийсэн аудитаар төсвийн төлөвлөлт, хэрэгжилттэй холбоотой **6,880.2** сая төгрөгийн зөрчил илэрч албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

- Зураг төсөв, үнийн тооцоо судалгаа нь урьдчилан хийгдээгүй **4,167.1** сая төгрөгийн төсөвт өртөгтэй **13** төсөл, арга хэмжээг аймгийн ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр төлөвлөж, баталсан,
- ОНХС-ийн чиг үүрэгт хамаарахгүй, төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжихгүй **2,477.4** сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 төсөл, арга хэмжээг аймгийн ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр баталсан,
- Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн батлагдсан төсвөөс **113.6** сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан,
- Зарцуулалтыг нь хууль, эрхийн актаар зохицуулаагүй аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлын төсвөөс улсын болон орон нутгийн төсөвт байгууллагуудад техник, тоног төхөөрөмж, хөрөнгө худалдан авах болон урсгал зардалд нийт **122.1** сая төгрөгийг зарцуулсан байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Сэлэнгэ аймгийн 2025 оны төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

Аймаг, сумдын ОНХО, ОНХС-ийн худалдан авах ажиллагааг Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хугацаанаас өмнө зохион байгуулж, гэрээ байгуулаагүйгээс шалтгаалан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт 11,183.0 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна.

- *Аймаг болон зарим сумдын татварын болон татварын бус суурь орлогыг өндрөөр төлөвлөж, баталсан байна.*
- *Зураг төсөв, тооцоо судалгаа нь урьдчилан хийгдээгүй төсөл, арга хэмжээнүүдийг аймгийн ОНХО болон ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.*
- *Улсын төсөвт хийгдсэн тодотголыг үндэслэн ОНХО, ОНХС-ийн хөрөнгө оруулалтын зардлыг нийт 11,183.0 сая төгрөгөөр бууруулан тодотгосон байна.*
- *Ногдол ашгийн орлого, сүү, ноос, ноолуур, хүнсний ногооны урамшуулал олгогдоогүйгээс 9 сумын төсвийн орлогын төлөвлөгөө 1,144.2 сая төгрөгөөр тасарсан байна.*
- *Өөрийн орлогыг ойн ангиуд үндэслэлгүй төлөвлөснөөс 72.0 сая төгрөгийн орлого нэмэгдүүлэх нөөц боломжийг алдсан байна.*
- *Аймаг, сумдын дүнгээр төсвийн зарлагын төлөвлөгөө 88.0 хувийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан байгаа нь ОНХО, ОНХС-ийн хэмнэлтээс голлон шалтгаалсан байна.*

- *Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө болон үйл ажиллагааны хөтөлбөрийн зардлаас хөрөнгө оруулалтын шинжтэй төсөл, арга хэмжээг санхүүжүүлсэн байна.*
- *Аймаг, сумын ОНХО болон ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт төсөл, арга хэмжээний 80.1 хувь нь бүрэн хэрэгжсэн байна.*

Аймгийн ТЕЗ-ийн анхааралд толилуулах нь:

Аудитаар Сэлэнгэ аймгийн 2025 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгасан **142,913.1** сая төгрөгийн орлого, **117,668.6** сая төгрөгийн зарлагын гүйцэтгэлийг баталгаажуулав.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Нэг. Аймгийн ИТХ-ын дарга Г.Бат-Орхонд

- Засаг даргаас өргөн мэдүүлж буй төсөл, арга хэмжээнээс бусад төсөвлөлтийн шаардлага хангаагүй ОНХО, ОНХС-ийн төсөл, арга хэмжээг ИТХ-аар хэлэлцүүлж, батлахгүй байх.

Хоёр. Аймгийн Засаг дарга Н.Лхагвадорж-д

- Монгол Улсын хөгжлийн 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлд тусгагдсаны дагуу ажлын байрны чиг үүргийн шинжилгээ хийх замаар ТЕЗ-ийн харьяа байгууллагын орон тоог 9 хувиар бууруулж ажиллах.
- ИТХ-аар батлагдсан нийт төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хуулийн хугацаанд зохион байгуулах замаар төсөл, арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг хангуулж ажиллах,
- Төсвийн орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр жигд ханган биелүүлэх замаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх, санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх,
- Төсөвт байгууллагуудын өөрийн орлогын төлөвлөгөөг үндэслэлтэй төлөвлөх замаар орлого нэмэгдүүлэх нөөц боломжийг ашиглах.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР

АУДИТОР



Б.БАТМӨНХ

Ц.ОТГОНБАЯР

Ж.ЦОГТ

Б.НАРАНЦЭЦЭГ

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИТХ-ЫН ТОГТООЛООР БАТЛАГДСАН 2025 ОНЫ ОРЛОГО



№	Орлогын төрөл	Сангийн яамнаас хянасан дүн	Аймгийн ИТХ-ын 2024.12.25 №12	Зөрүү	Аймгийн ИТХ-ын 2025.09.16 №43	Зөрүү
1	Аймгийн төсвийн татварын болон татварын бус орлого	34,670.86	40,727.92	6,057.06	45,332.38	4,604.46
2	Аймгийн төсвийн татварын орлого	32,473.86	36,952.20	4,478.34	41,547.66	4,595.46
2.1	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар	28,730.00	28,730.00	-	33,325.46	4,595.46
2.2	Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	1,153.00	1,153.00	-	1,153.00	-
2.3	Улсын тэмдэгийн хураамж	400.00	4,378.34	3,978.34	4,378.34	-
2.4	Ус ашигласны төлбөр	2,190.86	2,690.86	500.00	2,690.86	-
3	Аймгийн төсвийн татварын бус орлого	2,150.00	3,728.72	1,578.72	3,728.72	-
3.1	Хүү, торгуулийн орлого	1,000.00	1,000.00	-	1,000.00	-
3.2	Бусад орлого	1,000.00	2,578.72	1,578.72	2,578.72	-
3.3	Хөрөнгө борлуулсны орлого	150.00	150.00	-	150.00	-
4	Өөрийн орлого	47.00	47.00	-	56.00	9.00
4.1	Үүнээс: Аймгийн ЗДТГ	45.00	45.00	-	45.00	-
4.2	Худалдан авах ажиллагааны газар	2.00	2.00	-	11.00	9.00
5	Аймгийн төсвийн урьд оны үлдэгдэл		4,906.61	4,906.61	719.81	(4,186.80)
6	Аймгийн ОНХС-ийн урьд оны үлдэгдэл		2,068.34	2,068.34	1,884.38	(183.96)
7	ОНХНС-аас олгох шилжүүлэг	31,299.00	31,299.00	-	23,056.10	(8,242.90)
8	Сумын төсвөөс аймгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	13,140.00	4,835.34	(8,304.66)	8,040.88	3,205.54
8.1	Үүнд: Ерөө		728.00	728.00	728.00	-
8.2	Мандал		1,135.93	1,135.93	1,848.04	712.11
8.3	Сүхбаатар		2,619.95	2,619.95	4,752.27	2,132.32
8.4	Сайхан		88.18	88.18	330.19	242.01
8.5	Хүдэр		263.28	263.28	382.38	119.10
	Нийт орлогын дүн	79,109.86	83,837.21	4,727.35	79,033.55	(4,803.66)

СУМДЫН ТАТВАРЫН БОЛОН ТАТВАРЫН БУС ХЯНАГДСАН ОРЛОГЫГ НЭМЭГДҮҮЛЖ, БУУРУУЛСАН ДҮН

Хавсралт 2
 /Сая төгрөгөөр/
 241000
 9055436

Орлогын нэр төрөл	Алтанбулаг	Баянгол	Ерөө	Жавхланта	Зүүнбүрэн	Мандаг	Орхон	Орхонтуул	Сайхан	Сант	Сүхбаатар	Хушаат	Хүдэр	Цагааннуу	Цаамаг
Татварын орлого	28.6	199.2	1,978.0	3.4	96.7	(812.5)	106.7	0.0	39.5	22.4	96.0	18.5	75.4	10.0	22.0
ХХОАТ-ын орлого	8.6		2,940.0		29.4				118.5						
Үйл ажиллагааны орлого	(8.0)	136.2		5.0	75.7	613.2	123.9	127.2	125.0	58.9	833.1	58.5	(23.0)		
Хөрөнгийн орлого				(18.0)		(613.2)	(110.3)	(127.2)	(200.0)	(58.9)	(862.0)	(80.0)			
Хөрөнгө борлуулсны орлого				(3.3)								8.8			
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар				(2.1)	(1.4)			(10.0)				(8.8)	(17.0)		
Түгээмэл тархацтай АМАТ			(70.0)						(25.0)						13.5
Хог хаягдлын үйлчилгээний хураамж		28.0				23.0	47.7		21.0	4.0	124.9	0.8		10.0	8.5
Газрын төлбөр			(200.0)		(9.4)	(92.0)									
Дуудлага худалдаа	28.0	35.0	10.0	10.0	0.8	(200.0)	11.6			18.4		27.8			
Ойн нөөц ашигласны төлбөр			(700.0)			(548.7)							115.4		
Ан амьтны нөөц ашигласны төлбөр			(2.0)			0.2									
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр						5.0									
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр				11.8	1.6		33.8	10.0				11.4			
Татварын бус орлого	42.0	-	-	6.6	(12.3)	-	35.0	-	-	-	-	(5.0)	-	174.7	-
Торгуулийн орлого	42.0			6.6	5.0							3.0			
Бусад орлого					(17.3)		35.0					(8.0)		174.7	
Нийт дүн	70.6	199.2	1,978.0	10.0	84.4	(812.5)	141.7	-	39.5	22.4	96.0	13.5	75.4	184.7	22.0

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИТХ-ЫН ТОГТООЛООР БАТЛАГДСАН 2025 ОНЫ ЗАРЛАГА

Хавсралт 3
/Сая төгрөгөөр/
ᠮᠤᠯᠤᠯᠤᠯᠤᠰᠤ
ᠰᠤᠮᠤᠨᠠᠭᠤᠯᠠᠭᠤᠨ
ᠰᠤᠮᠤᠨᠠᠭᠤᠯᠠᠭᠤᠨ

№	Орлогын төрөл	Сангийн яамнаас хянасан дүн	Аймгийн ИТХ-ын 2024.12.25 №12	зөрүү	Аймгийн ИТХ-ын 2025.09.16 №43	зөрүү
1	Аймгийн ИТХ	1,963.60	1,831.20	(132.40)	1,854.73	23.55
1.1	Үүнээс: ИТХ	703.60	1,121.20	417.60	1,264.73	143.55
1.2	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал	1,260.00	710.00	(550.00)	590.00	(120.00)
2	Аймгийн ЗДТГ	5,780.30	6,654.30	874.00	6,815.01	160.67
2.1	Үүнээс: ЗДТГ	5,078.30	5,854.33	776.03	5,815.01	(39.33)
2.2	Орон нутгийн нөөц сан	702.00	800.00	98.00	1,000.00	200.00
3	Байгаль орчин, аялал жуулчлалын газар	3,372.50	4,037.76	665.26	3,796.54	(241.22)
3.1	Үүнээс: БОАЖГ	2,430.70	3,095.96	665.26	2,933.91	(162.05)
3.2	Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээ	941.80	941.80	-	862.63	(79.17)
4	Худалдан авах ажиллагааны газар	340.00	387.70	47.70	361.36	(26.37)
5	Орон нутгийн өмчийн газар	418.90	391.40	(27.50)	466.07	74.65
6	Санхүүгийн хяналт, аудитын алба	476.00	476.80	0.80	463.24	(13.62)
7	Засаг даргын ерөнхий данс	982.65	4,689.60	3,706.95	4,775.57	85.94
7.1	Халамжийн сан	202.40	202.40	-	202.38	-
7.2	Гамшгаас урьдчилан сэргийлэх, тэмцэх	-	140.00	140.00	140.00	-
7.3	Ахмад настны хөгжил хамгаалал	96.15	96.15	-	96.15	-
7.4	Улаан загалмай нийгэмлэгээр гэрээгээр гүйцэтгүүлэх	-	70.00	70.00	70.00	-
7.5	Цөм сүргийн үржлийн ажил үйлчилгээ	-	20.00	20.00	20.00	-
7.6	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	-	800.00	800.00	1,000.00	200.00
7.7	Ус цаг уур, орчны шинжилгээ	-	30.00	30.00	30.00	-
7.8	Суурин газрын ус хангамж	-	30.00	30.00	30.00	-
7.9	Мал аж ахуйг хөгжүүлэх	624.10	624.10	-	624.15	-
7.10	Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх	81.00	81.00	-	81.00	-
7.11	Улсын төсвийн байгууллагуудад олгох орон нутгийн нэмэгдэл	-	2,258.00	2,258.00	2,143.94	(114.06)
7.12	Ариун цэврийн байгууламж	181.40	181.40	-	181.44	-
7.13	Хүүхэд хамгаалал	-	156.50	156.50	156.51	-
8	Биений тамир спортын газар	1,507.70	1,507.70	-	1,507.71	-
9	Сэлэнгийн долгио чуулга	384.60	384.60	-	384.65	-
10	Орон нутгийн судлах музей	206.76	206.76	-	206.76	-
11	Нийтийн номын сан	82.56	82.60	0.04	82.56	-
12	Сэлэнгэ аймаг дахь МСҮТ	1,002.50	1,002.50	-	1,002.49	-
13	Сэлэнгэ аймгийн Нэгдсэн эмнэлэг	1,283.00	1,283.00	-	2,287.97	1,004.97
14	Хөрөнгийн зардлын дээд хэмжээ	7,754.20	11,306.70	3,552.50	8,521.26	(2,785.43)
14.1	Үүнээс: Их засвар	4,466.50	4,952.20	485.70	3,887.11	(1,065.07)
14.2	Орон нутгийн хөрөнгө оруулалт	-	3,066.80	3,066.80	2,247.77	(819.04)
14.3	Замын сан	3,287.70	3,287.70	-	2,386.38	(901.32)
15	Аймгийн ОНХС	13,554.90	13,554.90	-	9,423.10	(4,131.80)
	Үүнд: Аймгийн ОНХС-ийн эхний үлдэгдлээс	2,068.34	2,068.34	-	1,884.38	(183.96)
	Аймгийн ОНХС-д хуваарилагдсан дүн	11,486.56	11,486.56	-	7,538.72	(3,947.84)
16	Аймгийн ОНХС-аас сумдад хуваарилах дүн	19,812.43	19,812.43	-	15,517.38	(4,295.05)
17	Аймгийн төсвөөс сумын төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	17,925.98	14,039.71	(3,886.27)	12,901.96	(1,137.75)
17.1	Алтанбулаг	-	894.70	894.70	764.43	(130.27)
17.2	Баруунбүрэн	-	988.27	988.27	917.38	(70.89)
17.3	Баянгол	-	65.90	65.90	32.40	(33.47)
17.4	Жавхланта	-	1,500.20	1,500.20	1,557.23	57.03
17.5	Зүүнбүрэн	-	1,221.50	1,221.50	1,118.25	(103.27)
17.6	Орхон	-	1,000.80	1,000.80	933.76	(67.03)
17.7	Орхонтуул	-	1,821.20	1,821.20	1,580.33	(240.87)
17.8	Сант	-	1,340.30	1,340.30	1,252.01	(88.30)
17.9	Түшиг	-	1,243.90	1,243.90	1,207.64	(36.23)
17.10	Хушаат	-	972.80	972.80	928.99	(43.78)
17.11	Цагааннуур	-	1,251.90	1,251.90	1,011.82	(240.04)
17.12	Шаамар	-	1,738.30	1,738.30	1,597.72	(140.62)
18	Аймгийн төсвөөс улсын төсөвт шилжүүлэх орлогын хэмжээ	2,187.40	2,187.40	-	8,665.20	6,477.80
	АЙМГИЙН НИЙТ ЗАРДЛЫН ДҮН	79,109.80	83,837.20	4,727.40	79,033.57	(4,803.65)

ЗУРАГ ТӨСӨВ, ҮНИЙН ТООЦОО СУДАЛГАА НЬ УРЬДЧИЛАН ХИЙГДЭЭГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

Хавсралт 4
 /Сая төгрөгөөр/
 9055436

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хэрэгжих хугацаа		Төсөвт өртөг	2025 онд санхүүжүүлэх нийт дүн	Зураг төсөв, тооцоо судалгаа хийсэн байдал
Аймаг, сумдын ОНХС						
1	Инженерийн шугам сүлжээний шинэчлэл /Алтанбулаг сум/	2025	2025	500.0	419.5	1/19/2025
2	Төрийн албан хаагчдын байр барих /Баруунбүрэн сум/	2025	2026	450.0	200.0	6/27/2025
3	Цэвэр усны шугам /Сайхан сум/	2025	2025	600.0	538.9	6/27/2025
4	Дулааны шугамын шинэчлэл /Түшиг сум/	2025	2025	100.0	100.0	1/15/2025
5	Гудамж талбайн гэрэлтүүлэг /Хушаат сум/	2025	2026	345.5	305.5	Үгүй
6	Малын үүлдэр угсаа сайжруулах эцэг мал худалдан авах /Хүдэр сум/	2025	2025	100.0	100.0	Үгүй
7	Автозам арчиглааны техник худалдан авах /Цагааннуур сум/	2025	2025	610.0	453.4	Үгүй
8	Хүүхдийн автобус /Сайхан сум/	2025	2025	250.0	220.0	Үгүй
9	Гүний худгийн усны насос, тоног төхөөрөмж /Гавшгай ус ОНӨААТҮГ/	2025	2025	100.0	87.0	Үгүй
10	Ариутгах татуургын шугамын засвар шинэчлэл /Ерөө сум, Бугант тосгон/	2025	2025	361.6	360.5	Үгүй
11	Байрны фасад засвар / Мандал сум, Спиртын байр/	2025	2025	600.0	528.0	Үгүй
12	Хараа голын гүүрийн засвар /Мандал сум, Түнхэл тосгон/	2025	2025	50.0	48.0	Үгүй
13	1-р хэсэг 60 айлын тоглоомын талбайн тохижилт /Сүхбаатар сум/	2025	2025	100.0	89.6	12/31/2024
14	Алтанбулаг сум " Аюулгүй өвс тэжээлийн нөөцийн саравчтай болох"	2025	2025	44.8	44.8	Үгүй
15	Сайхан сум "Хүүхдийн тоглоомын талбай байгуулах /2ш"	2025	2025	120.0	120.0	Үгүй
16	Сайхан сум "Наадмын талбай засварлах /Номгон хөтөл"	2025	2025	100.0	99.0	Үгүй
Аймгийн ОНХС						
1	Цэцэрлэгийн засвар /Зүүнбүрэн сум/	2025	2025	320.0	195.6	2/15/2025
2	Эрүүл мэндийн төвийн барилгын гадна фасад, дотор халаалтын засвар /Сайхан сум, Номгон тосгон/	2025	2025	187.9	182.4	1/13/2025
3	Захирагчийн албаны барилгын дотор сантехникийн засвар /Сайхан сум, Номгон тосгон/	2025	2025	95.2	85.0	5/19/2025
4	Аймгийн нэгдсэн музейн барилгын дээврийн засвар	2025	2025	127.2	127.0	2/10/2025
5	Аймгийн нэгдсэн музейн барилгын дотор засвар	2025	2025	101.4	78.6	2/10/2025
6	Соёлын төвд лед дэлгэц /Баянгол сум/	2025	2025	103.4	62.2	Үгүй
7	Сумын Засаг даргын Тамгын газарт тоног төхөөрөмж /Орхон сум/	2025	2025	104.8	72.5	Үгүй
8	Эрүүл мэндийн үйлчилгээний тоног төхөөрөмж /Орхон сум/	2025	2025	29.8	27.9	Үгүй
9	Өрхийн эмнэлэгийн хэрэгцээнд автомашин худалдан авах /Мандал сум/	2025	2025	100.0	94.8	Үгүй
10	Уламжлалтын тасгийн тоног төхөөрөмж /Аймгийн Нэгдсэн эмнэлэг/	2025	2025	20.0	20.0	Үгүй
11	Эрүүл мэндийн төвд тоног төхөөрөмж /Түшиг сум/	2025	2025	19.9	19.9	Үгүй
12	Багш хөгжлийн төвд тоног төхөөрөмж авах /Түшиг сум/	2025	2025	19.4	19.4	Үгүй
13	Цэцэрлэгт хяналтын камер авах /Зүүнбүрэн сум/	2025	2025	8.0	8.0	Үгүй
14	Захирагчийн албан зөөврийн компьютер /Шаамар сум, Дулаанхаан тосгон/	2025	2025	4.3	4.3	Үгүй
15	Цагдаагийн хэсгийн түр хяналтын цэгийн тоног төхөөрөмж /Ерөө сум, Бугант тосгон/	2025	2025	9.3	9.3	Үгүй
НИЙТ ДҮН				5,682.5	4,721.2	